



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 1 дүгээр сарын 26-
ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 30

ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Гамшигаас хамгаалах тухай хуулийн 16.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвартын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэлийн бодис, оношлуур худалдан авах болон иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах, сээрэмжлүүлэг, зөвлөмж хэвлүүлэн тараахад шаардагдах зардлыг 1 дүгээр хавсралт, Хилийн боомт дахь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа алба, хэлтэст нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардагдах зардлыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж, дээрх зардалд шаардагдах нийт 5.509.989.000 (таван тэрбум таван зуун есөн сая есөн зуун наян есөн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

2. Нэн шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 4.2 тэрбум төгрөгийн зардлыг Азийн хөгжлийн банктай хэлэлцэн тохиролцож, шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай. (Энэ заалтыг Засгийн газрын 2020 оны 48 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

3. Энэ тогтоолын 1, 2 дахь заалтад заасан багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдвартгүйтгэлийн бодис худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Монгол Улсын Шадар сайд Θ.Энхтувшин нарт зөвшөөрсүгэй.

4. БНХАУ-тай хиллэх хилийн авто замын боомтоор тээврийн хэрэгслээр болон явганаар нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнд түр хугацаагаар хязгаарлалт хийх асуудлыг Дипломат харилцаа, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хятадын талтай 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн дотор харилцан тохиролцож, шийдвэрлэхийг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатарт, хилийн боомтын хяналтыг сайжруулах арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

5. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл түр зогсоосонтой холбогдуулан ерөнхий боловсролын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, их, дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааг энэ оны 3, 4, 5 дугаар сарын долоо хоног бүрийн Бямба гарарт сунгаж хичээллүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.

6. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хөтөлбөрийн агуулгаар сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Чинбат)-т тус тус даалгасугай.

7. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан олон нийтийг хамарсан урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахгүй байх, хүүхдийн зуслан болон тоглоомын газруудыг ажиллуулахгүй байх, кино, үзвэрийн газарт 18 нааснаас доош насын хүүхдийг оруулахгүй байх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Шинэ коронавирусийн халдвартын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар бүх нийтэд үнэн, зөв мэдээллийг шуурхай хүргэж байхыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сээрэмжлүүлэг, зөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын Хэвлэл мэдээллийн алба (Ц.Ганзориг)-нд тус тус үүрэг болгосугай.

9. БНХАУ-ын Ухань хотод сурч байгаа монгол иргэдээ татаж авах асуудлыг судалж, шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.

10. Амьсгалын замын цочмог халдварт, томуу, томуу төст өвчинеөр өвчилсөн 5 хүртэлх насын хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарсан ажил хөдөлмөр эрхэлж байгаа эх, эцэг, асран хамгаалагчдад тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт зөвлөсүгэй.

11. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдвартгүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нартuriалсугай.

12. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Θ.Энхтувшинд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд
Монгол Улсын Шадар сайд
Сангийн сайд

У.ХҮРЭЛСҮХ
Θ.ЭНХТУВШИН
Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2020 оны 30 дугаар

тогтоолын 2 дугаар хавсралт

**ХИЛИЙН БООМТ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХАРЬЯА АЛБА, ХЭЛТЭСТ НЭН ШААРДЛАГАТАЙ БАЙГАА ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙГ
ХУДАЛДАН АВАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ**

№	Зардлын зүйл анги	Нийт (Төг)
1.	Зорчигчийн биеийн халууныг хэмжих суурин термокамер	780.000.000
2.	Дижитал гар термометр	65.000.000
3.	N 95 маск	125.000.000
4.	Хувийн хамгаалах хэрэгслийн иж бурдэл	219.960.000
5.	Ариутгал халтваргүйтгэлийн бодис	2.600.000
6.	Автомаск (5, 12 литр)	3.198.000
7.	Мананцар үүсгэж халдвартгүйжүүлэх төхөөрөмж	2.400.000
8.	Богино долгионы станц	20.800.000
	Нийт дүн	1.218.958.000

Засгийн газрын 2020 оны 30 дугаар

тогтоолын 1 дүгээр хавсралт

**ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын зүйл анги	Нийт (Төг)
1.	Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношуур, ариутгал халдвартгүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хэрэгсэл худалдан авах зардал	4.106.031.000
2.	Иргэдэд сургалт, сурталчилгаа явуулах, сэрэмжлүүлэг, зөвлөмж хэвлүүлэн тараахад шаардагдах зардал	185.000.000
	Нийт дүн	4.291.031.000